

БАТЛАВ:  
“МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН ХОЛБОО”  
ЕРӨНХИЙЛӨГЧ

..... /С.ЭНХСАЙХАН/

БАТЛАВ:  
“.....” ХХК-ний  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

..... /...../

## МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

2023 оны 3-р сарын . . . өдөр

№ . . .

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монголын Аюулгүй Байдал, Хамгаалалтын Нэгдсэн Холбоо (цаашид “Холбоо” гэх)-г төлөөлж Гишүүнчлэл, Хамтын Ажиллагааны Менежментийн хорооны дарга А.Ганхуяг (РД: ХЖ66051519) нөгөө талаас тус холбооны гишүүнээр элсэхээр хүсэлтээ ирүүлсэн “.....” ХХК (РД:.....) -ийг төлөөлж гүйцэтгэх захирал албан тушаалтай.....(РД:.....) (цаашид “Гишүүн байгууллага” гэх) нар харилцан тохиролцож Холбооны дүрэмд заасан зорилго, үйл ажиллагааг дэмжих, гишүүнийхээ эрхийг хамгаалуулж, үүргийг биелүүлж ажиллахын баталгаа болгож байгуулав.

### 1. Гэрээний зорилго

1.1 Холбооны дүрмээр хүлээсэн үүргээ Холбоо ба гишүүд харилцан биелүүлж, аюулгүй байдал, хамгаалалтын салбарын эрх ашгийг ямагт дээдлэн, хуулийн хүрээнд хамгаалан бэхжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулахыг эрэлхийлэх, гишүүд дэмжигчдийн оролцоотойгоор тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх, харилцан мэдээлэл солилцож, хөгжих, сургалт уралдаан тэмцээн зохион байгуулах, нийгмийн хариуцлагын ажил зохион байгуулах, холбооны үйл ажиллагаа явуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зэрэг нэгдмэл зохион байгуулалт бүхий харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

### 2. Гишүүний ёс зүй, эрх, үүрэг, хориглох зүйлс

#### 2.1 Гишүүний ёс зүй

Холбооны гишүүн нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга байх, аливаа асуудалд бодитой хандах, хараат бус байх, ур чадвартай байх, хариуцлагатай хандах, нууцыг

хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, мэргэжлийн болон салбарын нэр хүндээ эрхэмлэх зарчмуудыг баримтлан, гишүүний ёс зүйн дүрмийг чанд мөрдөнө.

## 2.2 Гишүүний эрх

2.2.1 Холбооны их хуралд оролцож Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох;

2.2.2 Гишүүн байгууллага нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулж, Холбооноос дэмжлэг авах;

2.2.3 Холбооноос зохион байгуулж буй гадаад болон дотоод арга хэмжээнүүдэд оролцох;

2.2.4 Холбооны мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглах;

2.2.5 Холбооны цахим хуудсаар байгууллагаа сурталчлуулах;

2.2.6 Холбооны үйл ажиллагааны талаар санал шүүмжлэл гаргах, холбогдох мэдээллийг гаргуулах;

2.2.7 Холбоог энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд гишүүнчлэлээ түдгэлзүүлэх саналаа бичгээр гаргах;

## 2.3 Гишүүний үүрэг

2.3.1 Гишүүн байгууллага нь Холбооны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг эрхэмлэн ажиллах үүрэгтэй.

2.3.2 Гишүүн байгууллага нь хууль, дүрэм, журмын төслүүдэд санал өгөх, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа болон Холбооноос зохион байгуулж буй аливаа арга хэмжээнүүдэд тогтмол идэвхтэй оролцох үүрэгтэй;

2.3.3 Гишүүн байгууллага нь гишүүнчлэлийн татварыг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар тогтоосон хэмжээ буюу нэг сарын 30,000 /гучин мянган/ төгрөг, нэг жилийн 360,000 /гурван зуун жаран мянган/ төгрөгийг тухайн жилийн эхний улиралд багтаан Холбооны ХААН банкны 5040511353, ХХБ-ны 415097487 тоот дансанд шилжүүлнэ.

2.3.4 Гишүүн байгууллага нь тухайн жилийн аль сард элсэж байгаагаас хамааран он дуусах хүртэлх үлдсэн саруудын татварыг бүтнээр нь тухайн сардаа багтаан дээр дурдсан дансанд шилжүүлнэ.

## 2.4 Гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно.

2.4.1 Өөрт эрх олгогдоогүй асуудлаар Холбоог төлөөлөх, түүний нэрийн өмнөөс мэдэгдэл хийх, үйл ажиллагаа явуулах;

2.4.2 Холбоонд тодорхой албан тушаал эрхэлж байхдаа болон гишүүний хувьд олж мэдсэн дотоод мэдээлэл, эсхүл байгууллага болон хувь хүний нууцыг задруулах;

2.4.3 Гишүүн нь ижил төстэй нэртэй байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох.

### **3. Холбооны эрх, үүрэг**

#### **3.1 Холбооны эрх**

3.1.1 Холбооны Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр гишүүнчлэлийн татварын хэмжээг тогтоох;

3.1.2 Гишүүн байгууллагыг гэрээгээр хүлээсэн үүрэг болон Холбооноос гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;

3.1.3 Гишүүн байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу гишүүн байгууллага хүсэлтээ бичгээр ирүүлсэн тохиолдолд Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гишүүнээс түдгэлзүүлэх;

#### **3.2 Холбооны үүрэг**

3.2.1 Гишүүн байгууллагын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, түүний нийтлэг эрх ашиг зөрчигдсөн асуудлаар холбогдох байгууллагуудад санал, хүсэлт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах;

3.2.2 Гишүүн байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэх;

3.2.3 Холбоо нь гишүүн байгууллагыг ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг дотооддоо болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран явуулах, ур чадварын болон спортын тэмцээн уралдаануудыг тогтмол зохион байгуулах;

3.2.4 Холбогдох хууль тогтоомж, Холбооны дүрэм, бодлогын баримт бичгийн боловсруулалтад гишүүн байгууллагын оролцоог хангах;

3.2.5 Гишүүн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сангийн бүтэц, мэдээллийн ангилал, ашиглалтыг тусгайлсан журмаар зохицуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

3.2.6 Гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн нэр хүндийг өргөх, нийт гишүүдийн идэвх санаачилгыг дэмжсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах;

3.2.7 Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайланг гишүүн байгууллагуудад нээлттэй танилцуулах;

### **4. Гэрээний хугацаа**

4.1 Энэхүү гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хугацаагүй хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.2 Гэрээг цуцлах талаар аль нэг тал бичгээр санал гаргаагүй бол гэрээг хүчинтэйд тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МАБХНХолбоог төлөөлж:

ГХАМХ-ны дарга:

.....

/ А.Ганхуяг /

И-мэйл: info@msia.mn

Утас: 9911-7508

Гишүүн байгууллагыг төлөөлж:

“.....” ХХК-ний  
Гүйцэтгэх захирал

.....

/ /

И-мэйл:

Утас: